



ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО



# ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН 2020 ОНЫ 1 ДҮГЭЭР САРЫН ТАНИЛЦУУЛГА

Улаанбаатар хот

2020 он



## АГУУЛГА

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ.....	3
ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	3
ОРШИЛ.....	4
ИНФЛЯЦ.....	5

## **ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ**

Хүснэгт 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 1 дүгээр сард.....	5
Хүснэгт 2. Инфляцын импортын барааны оролцооны түвшин, жил бүрийн 1 дүгээр сард.....	6
Хүснэгт 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2020 оны 1 дүгээр сард.....	7
Хүснэгт 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, бараа, үйлчилгээний бүлгээр, хувиар, жил бүрийн 1 дүгээр сард.....	8
Хүснэгт 5. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, өмнөх оны мөн үетэй харьцуулснаар, хувиар, жил бүрийн 1 дүгээр сард.....	9

## **ЗУРГИЙН ЖАГСААЛТ**

Зураг 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 1 дүгээр сард.....	6
Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар.....	8
Зураг 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, жил бүрийн 1 дүгээр сард (өмнөх оны мөн үеэс).....	10
Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс, (өмнөх оны 12 дугаар сар = 100%), хувиар.....	11
Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, жил бүрийн 1 дүгээр сард.....	11
Зураг 6. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн цул махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	12
Зураг 7. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	12
Зураг 8. Улаанбаатар хотод зарагдаж буй хонины ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	12
Зураг 9. Бензин, түлшний үнийн индекс, хувь, 2017-2020 он (өмнөх оны 12 сар=100%).....	13
Зураг 10. Улаанбаатар хотод зарагдаж буй АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр.....	13

## ОРШИЛ

Инфляцыг хэмжих хэд хэдэн арга байдгийн нэг нь хэрэглээний үнийн индекс юм. Инфляцын түвшинг тодорхойлох, төрөөс санхүү, мөнгө зээлийн бодлогыг хэрэгжүүлэх, хүн амын цалин, тэтгэвэр, тэтгэмж бусад орлогын хэмжээг индексжүүлэх тооцооны гол үзүүлэлт нь хэрэглээний үнийн индекс болдог. Түүнчлэн хэрэглээний үнийн индексийг макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн нэг болох дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн аргын тооцоонд болон эцсийн ашиглалтын тооцоог зэрэгцүүлэх үнэд шилжүүлэхэд ашиглана.

Үндэсний Статистикийн Хороо нь өөрийн чиг үүргийн хүрээнд өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн мэдээллийг сар бүр цуглуулж, хэрэглээний үнийн индексийг тооцон олон нийтийн хүртээл болгож байна.

Үндэсний Статистикийн Хороо 1991 оноос Олон Улсын Валютын Сангийн аргачлалаар хэрэглээний үнийн индексийг тооцож эхэлсэн ба түүнээс хойш суурь, сагс, жинг 1995, 2000, 2005, 2010, 2015 онуудад шинэчилсэн. 1991-2006 он хүртэл Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр хэрэглээний үнийн улсын индексийг төлөөлүүлэн тооцдог байсан. 1997 оноос аймгуудын индексийг тусад нь тооцож, зарлаж ирсэн.

Манай улсын нутаг дэвсгэр, газар зүйн байршлаас хамаарч, бараа, үйлчилгээний үнэ, тариф аймгуудад харилцан адилгүй, улсын хэмжээний нийт өрхийн талаас илүү хувь нь аймаг, орон нутагт амьдардаг зэргээс шалтгаалан хэрэглээний үнийн улсын индексийн тооцоонд аймгийн хэрэглээний үнийн индексийг оруулах шаардлагатай болсон. 2006 оны 1 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын хэрэглээний үнийн индексээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, олон улсын аргачлалын дагуу улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

2017 оны 4 дүгээр сараас эхлэн хэрэглээний үнийн индексийг 2015 суурьт шилжүүлэн хувийн зориулалттай хэрэглээний бараа, үйлчилгээний ангиллын /ХЗХБҮА/ үндсэн 12 бүлгийн дагуу 373 (Улаанбаатар хотод 344, аймгуудад 238 нэр төрөл) нэр төрлийн бараа, үйлчилгээгээр хэрэглээний үнийн индексийг тооцож байна.

## ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНИЙН ИНДЕКС

### Инфляц


Инфляцын түвшин 2017 оны 1 дүгээр сард 2.1 хувь, 2018 оны 1 дүгээр сард 6.9 хувь, 2019 оны 1 дүгээр сард 7.3 хувьтай гарч байсан бол 2020 оны 1 дүгээр сард 5.6 хувь болж, өмнөх оноос 1.7 пунктээр буурсан байна.

Хүснэгт 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 1 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2017 I	2018 I	2019 I	2020 I
<b>Ерөнхий индекс</b>	<b>100</b>	<b>2.1</b>	<b>6.9</b>	<b>7.3</b>	<b>5.6</b>
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	0.7	1.5	2.7	2.0
Согтууруулах ундаа, тамхи	4.4	0.1	0.4	0.2	0.1
Хувцас, бөс бараа, гутал	16.6	0.5	0.8	0.9	1.1
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	0.2	1.1	1.0	0.5
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	0.1	0.3	0.2	0.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	0.1	0.4	0.4	0.1
Тээвэр	14.4	0.0	1.6	0.9	0.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	-0.1	0.0	0.0	0.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	0.0	0.1	0.3	0.3
Боловсролын үйлчилгээ	4.8	0.2	0.3	0.3	0.5
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	0.1	0.1	0.2	0.3
Бусад бараа, үйлчилгээ	5.4	0.2	0.4	0.2	0.3

Инфляцын түвшин 2020 оны 1 дүгээр сард улсын хэмжээнд 5.6 хувь гарсныг бүлгүүдийн оролцооны түвшнээр авч үзвэл, 2.0 нэгж буюу (35.7 хувь) нь хүнсний бараа, ундаа, усны бүлгээс, 1.1 нэгж буюу (19.8 хувь) нь хувцас, бөс бараа, гутлын бүлгээс, 0.5 нэгж буюу (9.3 хувь) нь боловсролын үйлчилгээний бүлгийн үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Хүнсний бараа, ундаа, усны бүлэг 2019 оны 1 дүгээр сард инфляцид 36.8 хувиар нөлөөлж байсан бол 2020 оны 1 дүгээр сард 35.7 хувь болж, 1.1 пунктээр буурсан байна.

Зураг 1. Инфляцын бүлгүүдийн оролцооны түвшин, жил бүрийн 1 дүгээр сард



Хүснэгт 2. Инфляцын импортын барааны оролцооны түвшин, жил бүрийн 1 дүгээр сард

Үзүүлэлт	2018 I		2019 I		2020 I	
	Пункт	Хувь	Пункт	Хувь	Пункт	Хувь
<b>Ерөнхий индекс</b>	<b>6.9</b>	<b>100.0</b>	<b>7.3</b>	<b>100.0</b>	<b>5.6</b>	<b>100.0</b>
Импортын барааны нөлөө	3.5	51.2	2.3	31.2	2.2	38.7

Хэрэглээний бараа, үйлчилгээний сагсанд нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, Улаанбаатар хотын хэмжээнд 344 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг судалдаг. Нийт 373 нэр төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний 200 нь импортын бараа, бүтээгдэхүүн байдаг бөгөөд энэ нь нийт жингийн 45.5 хувийг эзэлдэг.

Инфляц 2020 оны 1 дүгээр сард 5.6 хувь гарсны 2.2 нэгж буюу 38.7 хувь нь импортын барааны үнийн өсөлтөөс шалтгаалсан байна. Импортын барааны өсөлтийн нөлөөлөл нь өмнөх оны мөн үеэс 0.1 пунктээр өссөн байна.


Хүснэгт 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувиар, 2020 оны 1 дүгээр сард

Бараа, үйлчилгээний бүлэг	Жин	2020 I 2019 I	2020 I 2019 XII
<b>Ерөнхий индекс</b>	<b>100.0</b>	<b>105.6</b>	<b>100.9</b>
Хүнсний бараа, ундаа, ус	26.1	107.8	102.9
Согтууруулах ундаа, тамхи	4.4	102.7	100.2
Хувцас, бөс бараа, гутал	16.6	106.7	100.3
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.3	105.2	100.4
Гэр ахуйн тавилга, бараа	4.9	104.0	100.2
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	3.6	103.3	100.3
Тээвэр	14.4	101.1	100.2
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.4	100.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	3.1	109.1	99.9
Боловсролын үйлчилгээ	4.8	109.7	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээ	3.0	109.3	100.3
Бусад бараа, үйлчилгээ	5.4	105.7	100.4

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 7.8 хувь (мах, махан бүтээгдэхүүний дэд бүлгийн үнэ 15.8 хувь, согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 4.0 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 2.7 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 6.7 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 5.2 хувь (цахилгаан, хийн болон бусад түлшний дэд бүлгийн үнэ 4.5 хувь), эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 3.3 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 1 дүгээр сард өмнөх сараас 0.9 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 2.9 хувиар (мах, махан бүтээгдэхүүн 7.0 хувь), хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.3 хувь, орон сууц, ус, цахилгаан түлшний бүлгийн үнэ 0.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зураг 2. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс (өмнөх оны мөн үеэс), хувь, сараар



Хүснэгт 4. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, бараа, үйлчилгээний бүлгээр, хувиар, жил бүрийн 1 дүгээр сард

Огноо	Бараа, үйлчилгээ	Улс	Улаанбаатар	Баруун бүс	Хангайн бүс	Төвийн бүс	Зүүн бүс
	<b>Ерөнхий индекс</b>	<b>102.1</b>	<b>101.7</b>	<b>102.3</b>	<b>102.0</b>	<b>103.1</b>	<b>102.6</b>
2017 I	Бараа	102.1	101.7	101.8	102.2	103.6	102.3
	Үйлчилгээ	102.0	101.8	103.9	101.6	101.2	103.6
	<b>Ерөнхий индекс</b>	<b>106.9</b>	<b>108.0</b>	<b>106.4</b>	<b>104.9</b>	<b>105.7</b>	<b>105.4</b>
2018 I	Бараа	107.8	109.3	107.1	105.4	106.5	106.7
	Үйлчилгээ	104.0	105.0	103.7	102.9	102.4	100.6
	<b>Ерөнхий индекс</b>	<b>107.3</b>	<b>108.1</b>	<b>106.5</b>	<b>106.4</b>	<b>106.0</b>	<b>106.7</b>
2019 I	Бараа	107.9	108.8	106.7	106.8	106.9	107.5
	Үйлчилгээ	105.5	106.4	105.8	104.6	102.5	103.4
	<b>Ерөнхий индекс</b>	<b>105.6</b>	<b>106.0</b>	<b>105.0</b>	<b>104.8</b>	<b>104.9</b>	<b>106.7</b>
2020 I	Бараа	105.3	105.8	103.5	104.8	104.7	106.6
	Үйлчилгээ	106.5	106.5	110.3	104.7	105.6	107.3

2020 оны 1 дүгээр сард Зүүн бүсэд барааны үнийн өсөлт 6.6 хувь, Баруун бүсэд үйлчилгээний үнийн өсөлт 10.3 хувь гарсан нь бусад бүсүүдээс хамгийн өндөр үзүүлэлт болж байна (Хүснэгт 4).


Хүснэгт 5. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, улс, бүсээр, хувиар, 1 дүгээр сард

Бүс, аймаг	2019 I	2020 I
<b>Ерөнхий индекс</b>	<b>107.3</b>	<b>105.6</b>
<b>Баруун бүс</b>	<b>106.5</b>	<b>105.0</b>
Баян-Өлгий	107.0	104.7
Говь-Алтай	105.8	104.5
Завхан	106.2	105.1
Увс	106.2	107.5
Ховд	106.7	103.1
<b>Хангайн бүс</b>	<b>106.4</b>	<b>104.8</b>
Архангай	107.5	106.5
Баянхонгор	106.1	104.7
Булган	105.6	105.2
Орхон	106.6	102.8
Өвөрхангай	109.1	105.5
Хөвсгөл	103.1	105.1
<b>Төвийн бүс</b>	<b>106.0</b>	<b>104.9</b>
Говьсүмбэр	105.7	106.7
Дархан-Уул	107.5	105.0
Дорноговь	106.5	105.6
Дундговь	104.2	107.7
Өмнөговь	107.5	103.3
Сэлэнгэ	104.8	103.5
Төв	105.5	105.1
<b>Зүүн бүс</b>	<b>106.7</b>	<b>106.7</b>
Дорнод	106.4	107.7
Сүхбаатар	106.0	105.1
Хэнтий	107.4	106.9
<b>Улаанбаатар</b>	<b>108.1</b>	<b>106.0</b>



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс бүх аймагт 2.8-7.7 хувиар өссөн байна. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 1 дүгээр сард Орхон аймагт 2.8 хувиар өссөн нь хамгийн бага, Дорнод, Дундговь аймагт 7.7 хувиар өссөн нь хамгийн их байна. (Зураг 3).

Зураг 3. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн индекс, хувь, аймаг, нийслэлээр, жил бүрийн 1 дүгээр сард (өмнөх оны мөн үеэс)




Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ Улаанбаатар хотод 2020 оны 1 дүгээр сард өмнөх сараас 1.2 хувь, өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өслөө.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 1 дүгээр сард өмнөх оны эцсээс 6.0 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ 8.9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 8.5 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлгийн үнэ 15.3 хувь, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны үйлчилгээний үнэ 9.5 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Улаанбаатар хотод хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2020 оны 1 дүгээр сард өмнөх сараас 1.2 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 3.6 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ 0.6 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.


Улаанбаатар хотод 2020 оны 1 дүгээр сард өмнөх сараас хэрэглээний сагсны 344 нэрийн бараа, үйлчилгээний 19.8 хувь буюу 68 бараа, үйлчилгээний үнэ өсөж, 9.6 хувь буюу 33 бараа, үйлчилгээний үнэ буурч, 70.6 хувь буюу 243 бараа үйлчилгээний үнэ өөрчлөлтгүй байв. Судалгаанд сонгогдсон хүнсний 100 нэрийн барааны 40 нэрийн барааны үнэ нэмэгджээ.

Зураг 4. Мах, махан бүтээгдэхүүний үнийн улсын индекс, (өмнөх оны 12 дугаар сар = 100%), хувь




2020 оны 1 дүгээр сард мах махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны эцсээс 7.0 хувиар өссөн байна. Үүнд үхрийн махны үнэ 6.6 хувь, хонины ястай махны үнэ 11.0 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

Зураг 5. Мах, махан бүтээгдэхүүний оролцооны түвшин, жил бүрийн 1 дүгээр сард




Инфляц 2020 оны 1 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 5.6 хувиар өссөн бөгөөд 1.2 нэгж буюу 22.3 хувь нь мах, махан бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс шалтгаалсан байна.

Зураг 6. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн цул махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа үхрийн цул махны дундаж үнэ 2020 оны 1 дүгээр сард 12 473 төгрөгийн үнэтэй байгаа нь 2017 оны 1 сараас 51.6 хувь, 2018 оны 1 сараас 55.9 хувь, 2019 оны 1 сараас 15.6 хувиар өссөн байна.

Зураг 7. Улаанбаатар хотод зарагдаж буй үхрийн ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа үхрийн ястай махны дундаж үнэ 2020 оны 1 дүгээр сард 10 524 төгрөгийн үнэтэй байгаа нь 2017 оны 1 сараас 55.3 хувь, 2018 оны 1 сараас 59.2 хувь, 2019 оны 1 сараас 18.8 хувиар өссөн байна.

Зураг 8. Улаанбаатар хотод зарагдаж буй хонины ястай махны дундаж үнэ, сараар, төгрөгөөр




Улаанбаатар хотод зарагдаж байгаа хонины ястай махны дундаж үнэ 2020 оны 1 дүгээр сард 8 590 төгрөгийн үнэтэй байгаа бөгөөд 2017 оны 1 сараас 52.1 хувь, 2018 оны 1 сараас 64.2 хувь, 2019 оны 1 сараас 20.0 хувиар өссөн байна.

Зураг 9. Бензин, түлшний үнийн индекс, хувь, 2017-2020 он (өмнөх оны 12 сар=100%)



2020 оны 1 дүгээр сард бензин, түлшний үнэ өмнөх оны эцсээс 0.5 хувиар өсжээ.

Зураг 10. Улаанбаатар хотод зарагдаж буй АИ-92 бензиний дундаж үнэ, сараар, төгрөгөөр



2020 оны 1 дүгээр сард АИ-92 бензиний дундаж үнэ 1 836 байгаа нь 2017 оны 1 сараас 20.0 хувь, 2018 оны 1 сараас 12.6 хувь, 2019 оны 1 сараас 5.6 хувиар өссөн байна.